

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/58/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 261740 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Грант Торнтон Аудит” ХХК Захирал: Б.Осоргарав Утас: 70110744 Цахим хаяг: info@mn.gt.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ БАТМӨНХ ТАНАА

2024.02.29 № 07/589
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагаа 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон ба харилцагч байгууллагуудын үлдэгдэл төлбөрийг хийх, Дэлхийн банкны үлдэгдэл санхүүжилтийг буцаан шилжүүлэх, санхүүжилтээс бусад орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх, тусгай дансыг хаах ажил гүйлгээнүүдийг дараагийн төсвийн жилд буюу 2024 онд хийж хаалтын санхүүгийн тайлангаа бэлтгэн гаргах төлөвлөгөөтэй байна.

Төсөл нь 2023 оны санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Тайлант хугацаанд төсөл нь батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөсөн ажил гүйлгээг тасралтгүй байдлаар явуулна гэсэн урьдчилсан нөхцөлтэйгөөр буюу зээлийн гэрээний дагуу хийгдэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны цар хүрээг материаллаг хэмжээгээр багасгах эсвэл сөрөг нөхцөлөөр ажил гүйлгээг зогсоох асуудлууд гараагүй тул төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд тайлант хугацаанд тасралтгүй байдлын нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсөл нь 10 нэр төрлийн 3,842.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын тушаал шийдвэргүй, Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/131 дүгээр тушаалыг үндэслэн Сангийн яаманд шилжүүлж данснаас хассан байна.

Дэлхийн банкны санхүүжилтийг нөхөн дүүргэлт хэлбэрээр хүлээн авч холбогдох данснуудыг зузаатгадаг ба нөхөн дүүргэлтийн дээд хязгаар 12,000.0 мянган ам.доллар болно. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 45 удаагийн 12,196.9 мянган ам.долларын нөхөн дүүргэлтийг хүлээн авч, 12,186.8 мянган ам.долларын зарцуулалт хийхээр гэрээлсэн ба нийт 12,000.0 мянган ам. долларын санхүүжилтийн ашиглалт 101.6 хувьтай байна.

Бусад асуудлын хэсэг

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл нь Дэлхийн банкнаас баталсан "Санхүүгийн удирдах гарын авлага"-д заасан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг, Дэлхийн банканд хүргүүлдэг бол Монголын Засгийн газарт санхүүгийн тайланг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн Газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягтууд, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал", УСНББОС-1-ийн дагуу аккрузл сууриар илэрхийлэн бэлтгэж, Төрийн аудитын байгууллагад хүргүүлдэг байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\10229 SNAG-34.Docx

АГАУ-ын 2006-109
9023030583

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,815,753,144.22	266,614,318.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,815,753,144.22	266,614,318.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,815,753,144.22	266,614,318.00
3121	Төгрөг	206,322,662.44	208,029,748.54
31211	Төрийн сангийн харилцах	206,322,662.44	208,029,748.54
3122	Гадаад валют	1,609,430,481.78	58,584,569.46
31221	Төрийн сангийн харилцах	1,609,430,481.78	58,584,569.46
31223	Арилжааны банк дахь харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
33401	Дансны авлага	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	26,311,178.82	7,320,440.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,311,178.82	7,320,440.15
392	Биет хөрөнгө	24,349,346.58	7,320,440.15
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,667,714.00	50,935,442.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,497,164.45)	(50,935,442.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,918,050.37	11,785,630.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,739,253.34)	(4,465,190.81)
393	Биет бус хөрөнгө	1,961,832.24	-
39301	Программ хангамж	11,470,000.00	11,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,508,167.76)	(11,470,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,842,064,323.04	273,934,758.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,526,359.64	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,526,359.64	-
413	Өглөг	23,526,359.64	-
4136	Бусад өглөг	23,526,359.64	-
41363	Татварын өглөг	23,526,359.64	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,818,537,963.40	273,934,758.15
51	Засгийн газрын хувь оролцоо	1,818,537,963.40	273,934,758.15
512	Хуримтлагдсан үр дүн	1,818,537,963.40	273,934,758.15
51210	Өмнөх үеийн үр дүн	466,936,363.32	1,818,537,963.40
51220	Тайлант үеийн үр дүн	1,351,601,600.08	(1,544,603,205.26)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,842,064,323.04	273,934,758.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,672,540,566.80	3,436,291,355.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,672,540,566.80	3,436,291,355.37
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,330,994.18
120002	Хүүгийн орлого	-	6,330,994.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,672,540,566.80	3,427,051,839.57
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	8,672,540,566.80	3,427,051,839.57
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	2,908,521.62
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,077,086,654.52	4,982,544,224.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,077,086,654.52	4,982,544,224.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,077,086,654.52	4,982,544,224.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,784,710.84	137,124,000.00
210101	Үндсэн цалин	238,784,710.84	137,124,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,023,088.86	17,140,400.00
210201	Тэтгэврийн даатгал	20,775,047.53	11,655,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,321,847.11	1,371,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,196,201.69	1,097,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	742,541.42	274,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,987,451.11	2,742,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,540,000.00	59,088,888.89
210304	Байрны түрээс	40,540,000.00	59,088,888.89
2104	Хангамж, бараа материалын зардал	120,080,707.24	25,572,703.86
210401	Бичиг хэрэг	2,377,500.00	13,308,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,118,807.24	5,144,113.85
210404	Ном, хэвлэл	102,943,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,641,400.00	7,120,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,572,161,538.93	4,717,595,917.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,555,196,583.44	4,700,089,293.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,454,545.45	15,090,909.09
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,510,410.04	2,415,715.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,496,608.65	26,022,314.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,466,335.50	7,965,645.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,030,273.15	18,056,668.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,595,453,912.28	(1,546,252,868.90)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	133,853,987.80	14,600,255.34
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	133,853,987.80	14,600,255.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	377,706,300.00	12,950,591.69
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	3,842,591.69
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	377,706,300.00	9,108,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)	(243,852,312.20)	1,649,663.65
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,351,601,600.08	(1,544,603,205.25)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	466,936,363.32	466,936,363.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	466,936,363.32	466,936,363.32
Тайлант үеийн үр дүн	-	-	1,351,601,600.08	1,351,601,600.08
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	1,818,537,963.40	1,818,537,963.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,818,537,963.40	1,818,537,963.40
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,544,603,205.25)	(1,544,603,205.25)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	273,934,758.15	273,934,758.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,672,540,566.80	3,433,382,833.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,672,540,566.80	3,433,382,833.75
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,330,994.18
120002	Хүүгийн орлого	-	6,330,994.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,672,540,566.80	3,427,051,839.57
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	8,672,540,566.80	3,427,051,839.57
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,155,334,104.78	4,988,013,915.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,155,334,104.78	4,988,013,915.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,155,334,104.78	4,988,013,915.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,784,710.84	137,124,000.00
210101	Үндсэн цалин	238,784,710.84	137,124,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,023,088.86	17,140,400.00
210201	Тэтгэврийн даатгал	20,775,047.53	11,655,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,321,847.11	1,371,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,196,201.69	1,097,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	742,541.42	274,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,987,451.11	2,742,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,540,000.00	59,088,888.89
210304	Байрны түрээс	40,540,000.00	59,088,888.89
2104	Хангамж, бараа материалын зардал	120,080,707.24	25,572,703.86
210401	Бичиг хэрэг	2,377,500.00	13,308,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,118,807.24	5,144,113.85
210404	Ном, хэвлэл	102,943,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,641,400.00	7,120,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,653,439,262.34	4,741,122,277.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,636,474,306.85	4,723,615,652.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,454,545.45	15,090,909.09
210808	Банк, санхүүгийн байгууллагын хураамж	5,510,410.04	2,415,715.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,466,335.50	7,965,645.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,466,335.50	7,965,645.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,517,206,462.02	(1,554,631,081.56)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	377,706,300.00	9,108,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	377,706,300.00	9,108,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	377,706,300.00	9,108,000.00
222001	Тоног төхөөрөмж	377,706,300.00	9,108,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (6)=(4)-(5)	(377,706,300.00)	(9,108,000.00)
14	Бусад эх үүсвэр	133,853,987.80	14,600,255.34
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	133,853,987.80	14,600,255.34
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	133,853,987.80	14,600,255.34
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,273,354,149.82	(1,549,138,826.22)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	542,398,994.40	1,815,753,144.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,815,753,144.22	266,614,318.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,004,219,400.00	4,997,121,915.30	7,097,484.70	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	4,995,111,400.00	4,988,013,915.30	7,097,484.70	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,995,111,400.00	4,988,013,915.30	7,097,484.70	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,124,000.00	137,124,000.00	-	99.0
Үндсэн цалин	137,124,000.00	137,124,000.00	-	99.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,140,400.00	17,140,400.00	-	99.0
Тэтгэврийн даатгал	11,655,500.00	11,655,500.00	-	99.0
Тэтгэмжийн даатгал	1,371,200.00	1,371,200.00	-	99.0
ҮОМШӨ-ний даатгал	1,097,000.00	1,097,000.00	-	99.0
Ажилгүйдлийн даатгал	274,200.00	274,200.00	-	99.0
Эрүүл мэндийн даатгал	2,742,500.00	2,742,500.00	-	99.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,089,000.00	59,088,888.89	111.11	99.0
Байрны түрээс	59,089,000.00	59,088,888.89	111.11	99.0
Хангамж, бараа материалын зардал	25,621,000.00	25,572,703.85	48,296.15	99.0
Бичиг хэрэг	13,350,000.00	13,308,300.00	41,700.00	99.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,150,000.00	5,144,113.85	5,886.15	99.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,121,000.00	7,120,290.00	710.00	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,748,171,000.00	4,741,122,277.12	7,048,722.88	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,730,429,000.00	4,723,615,652.71	6,813,347.29	99.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,091,000.00	15,090,909.09	90.91	99.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,651,000.00	2,415,715.32	235,284.68	99.1
Бараа үйлчилгээний бусад зардал	7,966,000.00	7,965,645.44	354.56	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	7,966,000.00	7,965,645.44	354.56	99.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,108,000.00	9,108,000.00	-	99.0
Тоног төхөөрөмж	9,108,000.00	9,108,000.00	-	99.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,724,563,600.00	3,447,983,089.08	276,580,510.92	99.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,724,563,600.00	3,433,382,833.75	276,580,510.92	99.1
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,724,563,600.00	3,427,051,839.57	297,511,760.43	99.1
Бусад орлого	-	6,330,994.18	(6,330,994.18)	(100.0)

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Ханшийн зөрүү	-	-	(14,600,255.34)	(100.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,815,753,144.22	-	.
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(1,279,655,800.00)	266,614,318.00	-	.
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын дүн	-	14,600,255.34	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
Төсвийн байгууллага	1	1		100
АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5		100
Удирдах ажилтан	1	1		100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 15.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсөл хэрэгжүүлэх нэгж нь ханш буруу тооцсоноос Хүүгийн орлого данс 0.3 мянган төгрөгөөр, ханшийн зөрүүний олз 359.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх АҮТХураамж 0.1 мянган төгрөгөөр тус тус дутуу бүртгэж зөрүү 360.0 мянган төгрөгийг Банкны шимтгэл дансанд бүртгэсэн тооцооллын алдаа гаргасан байна.	1	360.0			1		1	360.0				
Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 2023 оны хагас жилийн байдлаар цалингийн зардлыг 14,594.6 мянган төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэлийг 574.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан ба зөрүүг БГАҮХ дансанд 15,168.6 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.	1	15,168.6			1		1	15,168.6				
Дүн	2	15,528.6			2		2	15,528.6				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитаар нийт 10.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 6.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3.8 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
СЯ-ны ТНБД-ын 2023.02.20-ны өдрийн 03/1016 дугаар тушаалаар төслийн Санхүүгийн ажилтныг томилж, цалинг 4,524.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Цалинг тогтоохдоо тухайн үед давхар хэрэгжиж байсан Монгол улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн ажлын нэмэгдэл 30 хувийг жишиг цалин дээр нэмж тооцсон байна. "Монгол улсад засаглалыг бэхжүүлэх" төсөл 2023.06.28-нд албан ёсоор хаагдсан тул тайлант хугацаанд 6,624.0 мянган төгрөгийн илүү цалин олгогдсон байна.	1	6,264.0			1	6,264.0						
Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, шийдвэргүйгээр тус төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20,280.3 мянган төгрөгийн өртөгтэй, 16,437.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 26 нэр төрлийн тавилга эд хогшил, компьютер хэрэгслийг Сангийн яаманд 2023.06.15-нд шилжүүлж, хүлээлгэн өгсөн байна.	1	3,842.6					1	3,842.6				
Дүн	2	10,106.6			1	6,264.0	1	3,842.6				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.